



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/13

Бөхт

Засаг даргын Тамгын газрын бүтэц орон  
тоог батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын 2024 оны бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.


2. Манлайлах ур чадвараа дээшлүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хариуцлагатай, идэвх санаачилгатай хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны  
өдрийн А/13дугаар захирамжийн хавсралт



№	Ажлын байрны нэр	Орон тоо	Хариуцах чиг үүрэг
1	Засаг дарга	1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх
2	Засаг даргын орлогч	1	Сумын дэд бүтэц, тохижилт, орон нутгийн хөгжлийн сан, худалдан авах ажиллагаа
3	ЗДТГ-ын дарга	1	Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилтыг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих, Засаг даргад бодлогын зөвлөгөө мэргэшил аргазүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах, Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг хариуцах
4	Хууль эрхзүй олон нийт хариуцсан мэргэжилтэн	1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчилах, мэдээллээр хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрхзүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, гүйцэтгэл, үр дүнг хариуцна.
5	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	1	Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах гүйцэтгэлийн үр дүнг хариуцна.
7	Байгаль орчны мэргэжилтэн	1	Байгаль орчныг хамгаалах багц хууль, төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, зөрчил хянан шийдвэрлэх тухай, захиргааны ерөнхий хууль болон холеогдон гарсан стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж гүйцэтгэл, үр дүнг хариуцна.
8	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1	Архив, албан хэрэг хөтлөлт, архив, мэдээллийн технологи
9	Жолооч	1	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, машин техникээр үйлчлэх
<b>Санхүүгийн алба</b>			
10	Санхүүгийн албаны дарга	1	Төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сумын төсөвт байгууллагын төсвийн орлого, зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлага мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, бодит мэдээ мэдээллээр хангах, чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Сумын засаг даргын өмнө хариуцна.
11	Төрийн сангийн мэргэжилтэн	1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд, төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагуудад төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх, статистик мэдээллийг хариуцан ажиллаж ажлын гүйцэтгэлийн үр дүнг Сумын ЗДТГ-ын даргын өмнө хариуцна.
12	Нягтлан бодогч	1	Нийтийн ерөнхий үйлчилгэний санхүүгийн үйл ажиллагааг хариуцан тайлагнах
13	Нягтлан бодогч	1	Соёл, тусгай сангийн үйл ажиллагааг хариуцан тайлагнах
14	Нярав	1	Аж ахуй, үйлчилгээ, санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөлт
<b>Хөдөө аж ахуйн тасаг</b>			
15	Хүнс ЖДҮ	1	Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, жижиг

	хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн		дунд үйлдвэрлэлийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг ЗДТГ-ын даргын өмнө хариуцна.
16	Мал аж ахуй үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	Мал аж ахуй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малын генетик нөөцийг ашиглах, хамгаалах, сайжруулах, мал үржлийн ажил үйлчилгээ, бүртгэлийг зохион байгуулах, сурталчилах, тайлагнах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэлийн стандартыг хангуулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, тэжээл усан хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг ханган гүйцэтгэлийн үр дүнг Сумын ЗДТГ-ын даргын өмнө хариуцна
<b>Гэрээт</b>			
16	Үйлчлэгч	1	Туслах үйлчилгээ
17	Жолооч Сантехникч, цахилгаанчин	1	Хог зөөврийн машиныг жолоодох Байгууллагын сантехник, цахилгаанчны засвар үйлчилгээ,
<b>Багийн бүтэц орон тоо</b>			
18	1-р багийн Засаг дарга	1	Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, хууль тогтоомжийг сурталчлах, статистик мэдээ, аймаг сум багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх
19	2-р багийн Засаг дарга	1	
20	3-р багийн Засаг дарга	1	

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР